“БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 06 сарын 25 өдөр Дугаар 1/82 . Улаанбаатар хот

Журам батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, “Баганууурын дулааны станц”ТӨХК-ийн Хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь :

1. “Баганууурын дулааны станц”ТӨХК-ийн ИТА нарт мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэргийн нэмэгдэл олгох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга (Б.Ариунжаргал), Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга (Б.Солонго) нарт тус тус үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.АРИУН-ЭРДЭНЭ

"Багануурын дулааны станц"ТӨХК-ийн
Гүйцэтгэх захирлын 2024 оны 05 сарын 25-ны
өдрийн 1/82 дүгээр тушаалын хавсралт

"Багануурын дулааны станц"ТӨХК-ийн ИТА нарт мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэргийн нэмэгдэл олгох журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1"Багануурын дулааны станц" ТӨХК-ийн инженер техникийн ажилтнуудын мэдлэг, мэргэшлийн ур чадвар, түвшин, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, бүтээл, туурвилыг үнэлэх, тэдний ажил үйлчилгээний чанарт тавих шаардлага, гүйцэтгэлийг хянах, үр дүнг тооцоход энэхүү журмын зорилго оршино.

1.2 Инженер техникийн ажилтан нь мэргэжлээрээ зөвлөгөө өгөх, бие даасан мэргэжлийн санал дүгнэлт гаргах, сургалт явуулах, ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах, ажил албан тушаалыг мэргэшсэн хүний нөөцөөр бүрдүүлэх, мэргэжил, мэргэшлээ дээшлүүлэхийг дэмжин мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэргийн нэмэгдлийг хамтын гэрээнд заасан хувиар олгоно.

Хоёр.Мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэргийн нэмэгдэл олгох шаардлага

2.1 Дараах шаардлагыг хангасан бол мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэргийн нэмэгдлийг олгоно.Үүнд:

2.1.1 Мэргэшсэн болон зөвлөх зэргийн эрхийн хугацаа хүчин төгөлдөр байх

2.1.2 Тухайн мэргэжлийн чиглэлээрээ ажиллаж байх

2.1.3 Үр дүнгийн тайланг хугацаанд нь тайлагнасан байх

2.2 Дараах тохиолдолд мэргэшсэн болон зөвлөх зэргийн нэмэгдэл олгохгүй.

2.2.1 Тухайн мэргэжлийн чиглэлээрээ ажиллаагүй бол

2.2.2 Мэргэшсэн болон зөвлөх зэргийн эрхийн хугацаа сунгуулаагүй байх

2.2.3 Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тайланг хамгаалаагүй тохиолдолд

Гурав.Мэргэшсэн болон зөвлөх зэрэгтэй ажилтны үүрэг

3.1 Мэргэшсэн болон зөвлөх зэрэгтэй инженер техникийн ажилтан нь гүйцэтгэх ажлаа хууль тогтоомж, норм стандарт, журам заавар, техник технологийн дагуу чанартай ашиг сонирхлын зөрчилгүйгээр заасан хугацаанд хийж гүйцэтгэж тайлагнах үүрэгтэй.

3.2 Ажлын гүйцэтгэлийн үр дүн, өөрийн буруугаас учирсан хохирлыг бүрэн хариуцаж, холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээх үүрэгтэй.

3.3 Бусад ажилтгнуудыг дагалдуулан сургах, сурган хүмүүжүүлэх үүрэгтэй.

Дөрөв. Бусад зүйл

4.1 Мэргэшсэн, зөвлөх зэрэгтэй инженер техникийн ажилтан нь улирал бүр байгууллагын Гүйцэтгэх захирлын зөвлөлд өөрийн хийж гүйцэтгэсэн ажлын тайланг хамгаалснаар дараагийн улирлын зэргийн нэмэгдэл авах эрхтэй.

Улирлын үр дүнгийн тайланг тухайн улирал дуусах сарын 20-ны дотор захирлын зөвлөлд тайлагнана.

4.2 Мэргэшсэн, зөвлөх зэрэгтэй инженер техникийн ажилтан нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тайланг хамгаалаагүй тохиолдолд дараагийн улирлын зэргийн нэмэгдлийг олгохгүй.